



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ**

2025 оны 9-р сарын 8-ны өдөр

АГУУЛГА

• Хурлын зар	4
• Хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэр	5
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол	6
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг	8
• Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал	
1. Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой мэдээлэл	9
2. Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл	14
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах тогтоолын төсөл	22
• Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн	24
• Санал авах хуудасны загвар	25



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2025 оны 7-р сарын 29-ний өдрийн №33 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг зарлаж байгаа тул хувьцаа эзэмшигч та бүхнийг оролцохыг урьж байна.

Хурлын өдөр:	2025 оны 9-р сарын 8-ны өдөр, Даваа гараг
Эхлэх цаг:	14:00 цаг (Бүртгэл 13:00 цагт эхэлж 13:55 цагт хаагдахыг анхаарна уу)
Байршил:	ГОВЬ ХК (Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр, 1-р давхар, Сургалтын танхим)
Хурлын хэлбэр:	Танхимаар
Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:	2025 оны 8-р сарын 18-ны өдөр
Хурлаар хэлэлцэх асуудал:	1. Компанийн хэлбэрийг өөрчлөх; 2. Компанийн дүрмийг шинээр батлах.
Хурлын материалтай танилцах:	Хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2025 оны 8-р сарын 5-ны өдрөөс эхлэн дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд: Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354); - Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn); - Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж; - Говь ХК-ийн Гоёо оффисын байрны 3-р давхарт байрлах - ТУЗ-ийн ажлын албаны өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.
Урьдчилан санал өгөх:	Хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр 2025 оны 9-р сарын 4-ний өдрийн дотор иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү: - Өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан өгөх; - Говь ХК дээр биечлэн ирж өгөх; - Шуудангаар илгээх (Говь ХК-ийн албан ёсны хаяг); - И-мэйлээр ирүүлэх (boardoffice@gobicashmere.com).
Хурал зохион байгуулах комисстой холбоо барих:	ТУЗ-ийн ажлын албаны утас: 9411-8277, 9499-5750 И-мэйл: boardoffice@gobicashmere.com
Говь ХК-ийн албан ёсны хаяг:	Улаанбаатар - 17062, ХУД, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Утас: 7013-9977, Факс: 7014-3081, Шуудангийн хайрцаг: 36/434, Говь ХК



ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАХ БОЛОМЖТОЙ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ, ХУГАЦАА, АРГА ХЭЛБЭР

- Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол;
 - Хурлын зар, хурлын дэг;
 - Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой мэдээлэл;
 - Компанийн дүрмийн шинэчилсэн төсөл;
 - Хурлаас гарах тогтоолын төсөл;
 - Хурлын санал авах хуудас;
 - Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой бусад мэдээлэл.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь **2025 оны 8-р сарын 5-ны өдрөөс эхлэн** дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354);
 - Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
 - Өөрийн харилцаж буй үнэт цаасны компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
 - Говь ХК-ийн Гоёо оффисын байрны 3-р давхарт байрлах ТУЗ-ийн ажлын албаны өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

GOBI



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 он 07 сар 29 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал” гэх)-ыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 60.4, 61.1.5, 62.1.4, 64.2, 65, 67, 71.1, 71.3, 76.1.2, Компанийн дүрмийн 6.1.2, 6.1.4, 6.1.7.5, 6.1.9.4, 6.2.7.3, 6.2.7.4 дугаар зүйл заалтуудыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Хурлын тов

- 1.1. Хурлыг **2025 оны 9-р сарын 8-ны Даваа гарагийн 14:00 цагт** Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн байр, 1-р давхар, Сургалтын танхимд **танхимын хэлбэрээр** хуралдуулсугай.

2. Хэлэлцэх асуудал, санал хураах журам

- 2.1. Хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй.
 - 2.1.1. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 2.1.2. Компанийн дүрмийг шинээр батлах.
- 2.2. Хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцах боломжтой баримт бичгийн жагсаалт, хугацаа, арга хэлбэрийг **Хавсралт 1-ээр** баталсугай.
- 2.3. Санал авах хуудасны загварыг **Хавсралт 2-оор** баталсугай.
- 2.4. Санал хураалтыг хурлын үеэр авахаас гадна урьдчилсан байдлаар компанийн шуудангийн хаяг, и-мэйл хаяг болон үнэт цаасны компаниар дамжуулан хүлээн авах ба урьдчилан санал авах сүүлчийн өдрийг **2025 оны 9-р сарын 4-ний өдрөөр** тогтоосугай.

3. Бүртгэл, мэдээлэл хүргүүлэх

- 3.1. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2025 оны 8-р сарын 18-ны өдрөөр** тогтоосугай.
- 3.2. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид **2025 оны 7-р сарын 30-ны өдөр** хүргүүлж, хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу **2025 оны 7-р сарын 31 болон 8-р сарын 15-ны өдрүүдэд** олон нийтэд зарлахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.
- 3.3. Хурлын зарын хэвлэлийн эхийг **Хавсралт 3-аар** баталсугай.

4. Хурлын баримт бичиг

- 4.1. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг **2025 оны 8-р сарын 5-ны өдрийн дотор** үнэт цаасны компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn



GOBI



“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 он 07 сар 29 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

5. Хурлын зохион байгуулалт

- 5.1. Хурлыг ТУЗ-ийн дарга **Ц.Баатарсайхан** даргалсугай.
- 5.2. Хурлын дэгийг **Хавсралт 4-өөр** баталсугай.
- 5.3. Хурал зохион байгуулах комиссыг **Хавсралт 5-аар** томилсугай.
- 5.4. Хурлын Тооллогын комиссыг **Хавсралт 6-аар** томилсугай.
- 5.5. Хурлын бэлтгэлийг хангаж, хэлэлцэх асуудалтай холбоотой баримт бичиг, мэдээллийг бэлдэх, дэгийн дагуу зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комиссын даргад үүрэг болгосугай.
- 5.6. Хурлын ирцийг бүртгэж Хурлын даргад мэдээлэх, саналын хурааж, тооллогын үр дүнг нэгтгэн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комиссын даргад үүрэг болгосугай.

6. Хурлын шийдвэрийн хэрэгжилт

- 6.1. Хурлын шийдвэр болон бусад холбогдох баримт бичиг, тайлан мэдээллийг холбогдох хууль журамд заасан хугацаанд олон нийтэд мэдээлж, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Б.ОРГИЛ

Ц.ОРГИЛБОЛД

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх <i>Тооллогын комиссын дарга Т.Мөнхзул</i>	14:00-14:02
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах <i>Хурлын дарга Ц.Баатарсайхан</i>	14:02-14:05
3. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:	
3.1 Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай танилцуулах <i>ТУЗ-ийн дарга Ц.Баатарсайхан</i>	14:05-14:20
3.2 Компанийн дүрмийн шинэчилсэн төслийг танилцуулах <i>Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр</i>	14:20-14:30
4. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт <i>Хүн тус бүр 2 минут /Нийт 20 минут/</i>	14:30-14:50
5. Санал өгөх зааварчилгаа танилцуулах, санал авах <i>10 минут</i>	14:50-15:00
6. Завсарлага /Санал хураалтын дүнг нэгтгэх/ <i>20 минут</i>	15:00-15:20
7. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах <i>Тооллогын комиссын дарга Т.Мөнхзул</i>	15:20-15:22
8. Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах <i>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ</i>	15:22-15:25
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хаах <i>Хурлын дарга Ц.Баатарсайхан</i>	15:25-15:30

Хурлын үргэлжлэх хугацаа: 1 цаг 30 минут

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



1. КОМПАНИЙН ХЭЛБЭРИЙГ ӨӨРЧЛӨХТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Говь ХК-ийн **2025 оны 09-р сарын 08-ны** өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
01-р тогтоолын 1-р хавсралт

“ГОВЬ” ХК-ИЙГ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ БОЛГОХ ЗАМААР ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

1	Зорилго	Говь ХК (цаашид “Компани” гэх)-ийн компанийн засаглалын хүрээг илүү нягт, уялдаа холбоотой, хялбар бүтэцтэй болгох, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлэх, дотоод зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөг сайжруулах, улмаар зах зээлд оновчтой зохицон ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулийн болон санхүүгийн шаардлагыг биелүүлж, хувьцаа эзэмшигчдийг үргэлжлүүлэн алдагдалд оруулахаас сэргийлэх			
2	Нөхцөл	Хувьцаа эзэмшигчдийн хурлаар (цаашид “ХЭХ” гэх) хэлэлцэж дэмжигдэх тохиолдолд			
3	Журам	Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх), Монголын Хөрөнгийн Бирж (цаашид “МХБ” гэх), Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (цаашид “ҮЦТХТ” гэх) зэрэг эрх бүхий байгууллагын дүрэм журам ба холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу			
4	Хугацаа	2025 оны 4 дүгээр улиралд багтаан. (Шаардлагатай тохиолдолд сунгасан ажиллагааны хугацаагаар)			
5	Үе шат	5.1. Бэлтгэл буюу Дотоодод шийдвэр гаргах	Хийгдэх ажиллагаа	Аргачлал, хууль, журмын зохицуулалт	Хугацаа
			Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) хуралдаж Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит бус хурлыг зарлах тухай шийдвэр гаргах	СЗХ-ны 377 дугаар тогтоол 2.1, 2.2, 2.3 дүгээр хэсэгт заасны дагуу: 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Ээлжит бус хурлыг зарлах тухай шийдвэр гаргана.	2025.07.29
			ХЭХ-ын зар, мэдэгдэл, холбогдох материалыг хүргүүлэх	СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу	Журамд заасан хугацаанд
			Компанид Аудит оруулах ажлыг зохион байгуулах	Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 дугаар зүйлийг үндэслэн хяналт шалгалт хийлгэнэ.	2025.08.09-ний дотор
			Хараат бус үнэлгээний байгууллагаар хувьцааны үнэлгээ хийлгэх	Үнэт цаасны бүртгэлийн журмын 6.3.5-ийг үндэслэн СЗХ-нд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний компаниуд дундаас сонгон шалгаруулж, хувьцааны үнэлгээг хийлгэнэ	2025.09.08-ны дотор
		5.2. ХЭХ хуралдуулах	Компанийн хэлбэр өөрчлөх, ХХК-ийн дүрмийн төслийг батлах	ТУЗ-ийн санаачилгаар Компанийн тухай хуульд заасны дагуу явагдана.	2025.09.08
			ХЭХ-ын тайланг СЗХ, МХБ-д хүргүүлэх	СЗХ-ны 377 дугаар тогтоол 2 дугаар зүйлийн 2.10 дугаар зүйлд заасны дагуу Компани нь хурлын шийдвэрийг дагуу нэн даруй нийтэд мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.	2025.09.11-ний дотор



Үе шат	5.3. Арилжаа зогсоох хүсэлт гаргах	МХБ-ийн нээлттэй арилжааг түр зогсоох тухай хүсэлтийг гаргах	Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит бус хурлын шийдвэрийн хамт хүргүүлсэн огноор арилжааг зогсоолгохоор МХБ-д хүргүүлнэ	2025.09.11-ний дотор
	5.4. Хувьцаа эргүүлэн худалдан авах	ТУЗ-өөс шийдвэр гаргах	Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит бус хурлаас гаргасан шийдвэрийн дагуу Компанийн тухай хуулийн 53, 54, 55 дугаар зүйлийг хэрэгжүүлэх шийдвэр гаргана.	2025.09.09-ний дотор
		Хувьцаа эргүүлэн худалдан авах журам болон шийдвэрийг олон нийтэд мэдээлэх (давтан мэдээлэх)	Компанийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу шийдвэрийг мэдээлнэ.	Шийдвэр гарснаас хойш 5 хоногт
		ҮЦТХТ ТӨХХК-тай гэрээ байгуулах	Хувьцаа эргүүлэн худалдан авах шаардлага гаргасныг худалдан авах, худалдан авах ажиллагаа дууссаны дараа үлдсэн хувьцаа эзэмшгчдийн хувьцаанд ногдох мөнгийг ҮЦТХТ-ийн дансанд нь шилжүүлнэ.	Гэрээний хугацаанд
		Хувьцаа эргүүлэн худалдан авах шаардлага хүлээн авах	Хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг компани болон Үнэт цаасны компани дээр хүлээн авна.	Ажлын 30 хоногийн турш
		Хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт хүлээн авах	МХБ-ийн Үнэт цаасны Бүртгэлийн журмын 23.8-д заасан хүсэлтийг Компани, Үнэт цаасны компани, ҮЦТХТ дээр хүлээн авна.	Ажлын 30 хоногийн турш
		Хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардаагүй, хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт гаргаагүй бол ҮЦТХТ-ийн дансанд нь хувьцаанд ногдох мөнгийг шилжүүлэх ажиллагаа	МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 23.8-д зааснаар гүйцэтгэнэ.	ҮЦТХТ-тэй байгуулах гэрээгээр тохирсон хугацаанд
		Хувьцаа эзэмшигчийг үлдсэнд тооцон бүртгэх	СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 6.7-д заасны дагуу хувьцаа эзэмшигчид ногдох мөнгөн хөрөнгийг 2 сарын хугацаанд өөрийн дансанд шилжүүлж авах хүсэлтээ гаргаагүй тохиолдолд бүртгэлээс хасагдсан компанийн хувьцаа эзэмшигчээр үлдсэнд тооцно.	2 сарын хугацаанд
		МХБ-д мэдээлэх	Компанийн тухай хуулийн 53,54,55 дугаар зүйлд заасан арга хэмжээ, журмыг бүрэн хэрэгжүүлсэн талаар Хөрөнгийн биржийн Бүртгэлийн журмын 23.9-д заасны дагуу нотлох баримтын хамт мэдээлнэ.	2025.11.05-ны дотор
	5.5. МХБ-ийн бүртгэлээс хасагдах	МХБ-д үнэт цаасны бүртгэлээс хасагдах хүсэлтийг гаргах	Компанийн тухай хуульд нийцсэн гэж үзвэл шаардах эрх хэрэгжүүлж дууссанаас хойш компанийн хүсэлтийн дагуу шийдвэр гаргаж СЗХ болон ҮЦТХТ-д хүргүүлнэ.	Ажлын 3 хоногт
	5.6. СЗХ-ны бүртгэлээс хасагдах	СЗХ-ны бүртгэлээс хасагдах хүсэлтийг гаргах	СЗХ-ны Бүртгэлийн журмын 6.3-т заагдсан материалын хамт бүртгэлээс хасуулах хүсэлтийн дагуу шийдвэрлэж ажлын 10 хоногт багтаан Улсын бүртгэлд мэдэгдэнэ.	МХБ-ийн шийдвэр гарсны дараа



Үе шат	5.7. Улсын бүртгэлд бүртгүүлэх	ҮЦТХТ-ээс хувьцаа эзэмшигчээр үлдэх хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг гаргуулах	ҮЦТХТ-ийн мэдээгээр ХХК-ийн хувьцаа эзэмшлийн эрх, хэмжээг тодорхойлно.	СЗХ-ны шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт
		Говь ХХК болж компанийн хэлбэр өөрчлөгдсөн өөрчлөлт болон дүрмийг бүртгүүлэх	УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүсэлт гарган, компанийн өөрчлөлт, дүрмийг бүртгүүлнэ.	СЗХ-ны шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногт багтаан
	5.8. СЗХ-нд мэдээлэх	Шинэчилсэн дүрэм болон нэрсийн жагсаалтыг хороонд хүргүүлэх	СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 6.7-д зааснаар гүйцэтгэнэ.	Улсын бүртгэлд бүртгэгдсэний дараа
	5.9. Мэдээлэл түгээх	Харилцагч нарт өөрчлөлтийн мэдэгдлийг хүргүүлэх	Говь ХК-тай харилцаж буй төрийн болон хувийн хэвшлийн нийт харилцагчдад цахим орчин болон цахим шуудан ашиглаж мэдээллийг хүргэнэ.	
		Холбогдох төрийн байгууллага, татвар, нийгмийн даатгалд мэдээллээ өөрчлөх.		
	5.10. Өөрчлөх замаар үүссэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах	Гүйцэтгэх удирдлагаас Хувьцаа эзэмшигчдийн Ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах	Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, гишүүдийг сонгох, шаардлагатай бол дүрмийг шинэчилнэ.	ХХК-ийн дүрмийн дагуу хэдийд ч хуралдаж болно.
6	Хувьцаа харилцан хөрвүүлэх арга, тооцоо		Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, эсхүл хурлаас гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг биелүүлсний дараагаар шаардлагатай бол компанийн нийт хөрөнгө, гуравдагч этгээдэд хүлээсэн эрх үүрэг зэрэгт хөндлөнгийн үнэлгээг хийж, нэгж хувьцаанд ногдох хөрөнгийг тодорхойлох замаар харилцан хөрвүүлнэ.	
7	ХЭХ-ыг хуралдуулах хугацаа		2025 оны 9-р сарын 8-ны Даваа гарагийн 14:00 цагт танхимын хэлбэрээр	



“ГОВЬ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ БОЛГОХ ЗАМААР ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1. Компанийн тухай хуульд зааснаар энэхүү журам эсхүл төсөлд дурдсан нэр томьёог дараах агуулгаар ойлгоно. Үүнд:
- 1.1.1 Компанийн тухай хуулийн 3.7-д “Нээлттэй хувьцаат компани” гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ.
- 1.1.2 Компанийн тухай хуулийн 3.5-д “Хязгаарлагдмал хариуцлагатай компани” гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.

ХОЁР. ЗОРИЛГО

- 2.1. Говь ХК компанийн засаглалын хүрээг илүү нягт, уялдаа холбоотой, хялбар бүтэцтэй болгох, шийдвэр гаргалтын хурдыг нэмэгдүүлэх, дотоод зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөг сайжруулах, улмаар зах зээлд оновчтой зохицон ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулийн болон санхүүгийн шаардлагыг биелүүлж, хувьцаа эзэмшигчдийг үргэлжлүүлэн алдагдалд оруулахаас сэргийлэх

ГУРАВ. ҮНДЭСЛЭЛ, ШИЙДВЭР

- 3.1 Компанийн хэлбэрийг өөрчлөх төслийг хэрэгжүүлэх ажиллагааг ТУЗ-өөс томилсон Гүйцэтгэх удирдлага эрхлэн гүйцэтгэнэ. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч болон МХБ, СЗХ-нд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь хүртээмжтэй хүргүүлэх, Төслийг Компанийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон СЗХ, хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх төслийг хэлэлцэж Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд нийцүүлж шийдвэр гаргана. Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу Компанийн саналын эрхтэй нийт хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хэлэлцэж буй хурал хүчин төгөлдөр болно.
- 3.3 Компанийн тухай хуулийн 23.2, 63.7-д заасны дагуу Компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ. Ингэхдээ СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2-т заасныг хангахыг эрмэлзэнэ.

ДӨРӨВ. ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ БОЛГОХ ЗАМААР ӨӨРЧЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1 ХЭХ-аас Компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөхөөр шийдвэр гарсан тохиолдолд тухайн хурлын шийдвэрийг дагуу нэн даруй нийтэд мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор СЗХ болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- 4.2 Үнэт цаасны компанитай гэрээ байгуулсны дараа ажлын 5 хоногт МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 23.4 дүгээр зүйл, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 6.1 дүгээр зүйлд тус тус заасны дагуу хасагдах хүсэлтээ гаргана.
- 4.3 ХЭХ хуралдаж, Компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох шийдвэр гарсан тохиолдолд Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

ТАВ. КОМПАНИЙН ХЭЛБЭРИЙГ ӨӨРЧИЛЖ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ БОЛСНООР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ҮҮСЭХ ЭРХ

- 5.1 Компанийн хэлбэр өөрчлөх үед Компанийн хувьцаа эзэмшигч бүр нь Хязгаарлагдмал хариуцлагатай компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх эрхтэй байна. Компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтэй, эсхүл хувьцаагаа Компанид эргүүлэн ТУЗ-өөс тогтоосон үнээр худалдах хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь энэ тухай хүсэлтээ энэхүү журмын 9-д заасан зар анхлан нийтлэгдсэн өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор гаргах ёстой ба тус хугацаанд гаргаагүй бол энэхүү журмын 18-д заасны дагуу түүний хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг түүний дансанд нь шилжүүлж, түүнийг Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээс хассанд тооцно.
- 5.2 Дээрх үйл ажиллагаа мэдээгүй эсхүл өөрийн дансанд шилжүүлэх хүсэлтээ гаргаагүй хувьцаа эзэмшигч нь өөрчлөн байгуулсан компанийн удирдлагад хэдийд ч хүсэлт гаргаж хувьцаа эзэмшигчээр үлдэж болно.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХҮСЭЛТЭЭР КОМПАНИ ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

- 6.1 ХЭХ хуралдаж, Компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох шийдвэр гарсан тохиолдолд Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг ТУЗ нь шийдвэр гаргаж зохион байгуулна.
- 6.2 Хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр компани хувьцаагаа эргүүлэн худалдан авах ажиллагааг ТУЗ-ын хурлын тогтоол, түүний хавсралтад заасан “ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ”-ын дагуу зохион байгуулна.
- 6.3 Компанийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх төслийг баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигчийн гаргасан шаардлагын дагуу түүний хувьцааг эргүүлэн худалдаж авах болон “ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ”-ын дагуу Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх санал гаргаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох хөрөнгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд байрлах данс руу нь шилжүүлэхэд тус тус ашиглагдах уг компанийн нэгж хувьцааны үнийг ТУЗ-өөс тогтооно. ТУЗ нь шийдвэр гаргахдаа Компанийн тухай хуулийн 55.7-д заасны дагуу хараат бус үнэлгээний байгууллага болон аудитын байгууллагын дүгнэлт зэргийг харгалзсан байвал зохино.
- 6.4 Гэрээ байгуулсан үнэт цаасны компаниар дамжуулж хувьцаагаа худалдсан иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аас гаргасан жагсаалттай тулган хүлээн авах ажиллагааг ТУЗ, эсхүл түүнээс томилсон Гүйцэтгэх удирдлагын баг хариуцан гүйцэтгэнэ.
- 6.5 СЗХ-оос Компанийн хувьцааг бүртгэлээс хасахыг зөвшөөрсөн тогтоол гарснаас хойш ҮЦТХТ-өөс үлдсэн хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг гаргуулан компанийн хэлбэр өөрчлөх, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 6.6 Улсын бүртгэлд бүртгүүлсэн өөрчлөлт болон шинэчилсэн дүрмийн хуулбар, хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг СЗХ-нд хүргүүлнэ.
- 6.7 Шинээр өөрчлөн байгуулагдсан ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох болон бусад асуудлыг хэлэлцэн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулж болно.

Төрсөв.



2. КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН ТӨСӨЛ

Говь ХК-ийн 2025 оны 09 сарын 08-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
02-р тогтоолын 1-р хавсралт

“ГОВЬ” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Компанийн оноосон нэр (Монголоор)
- а) Бүрэн нэр “Говь” ХХК (цаашид “Компани” гэх)
б) Товчилсон нэр “Говь” ХХК
в) Англиар “Gobi” LLC
- 2.1 Компанийн оршин байгаа хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, үйлдвэрийн гудамж, өөрийн байр
- 3.1 Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Регистрийн дугаар	Хаяг	Утас
1	“Таван Богд Холдингс” ХХК	2543303	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, чингисийн өргөн чөлөө, 6, Стадион оргил-1, Хаан банк цамхаг, 10-р давхар, 1001 тоот	75112222
2	Олон нийт			

- 1.4 “Олон нийт” гэж Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад багтсан компанийн нийт хувьцааны 5 хувиас доош хувьцаа эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.
- 1.5 Компанийн Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын мэдээллийг үндэслэн гаргана.
- 1.6 Компани нь Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Иргэний болон Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хязгаарлагддаг, “Таван богд Холдингс” ХХК-ийн охин компани хэлбэрээр зохион байгуулагдсан Хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.
- 1.7 “Таван Богд Холдингс” ХХК /цаашид “толгой” компани гэх/ нь “Говь” ХХК-ний хувьд толгой компани нь байна. Толгой компани болон охин компанитай холбоотой харилцаанд компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг удирдлага болгоно.
- 1.8 Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдахаас бусад хуулиар хориглоогүй үйл ажиллагааг хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлсний үндсэн дээр чөлөөтэй эрхэлж болно.
- 1.9 Компани нь орлого, ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Үүнд:
- 1.9.1 Барааны дэлгүүр /4751/
1.9.2 Ямааны ноолуур, тэмээний ноосонд боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх /1311/
1.9.3 Гадаад худалдаа /4610/
- 1.10 Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлснээр эрхэлнэ.
- 1.11 Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 1.12 Компани нь өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох



зорилгоор Монгол улсын нутаг дэвсгэрт болон гадаадад салбар, төлөөлөгчийн газар, охин компанийг байгуулан ажиллуулж болно. Компанийн тухай хуулийн 7-р зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

- 1.13 Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж буй бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЭРХ

- 2.1 Компани нь өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Иргэний хууль, Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр хязгаарлагдана.
- 2.2 Компани нь өөртөө барааны тэмдэг болон билэгдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг (тамга) хэрэглэнэ.
- 2.3 Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.
- 2.4 Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 2.5 Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд үйл ажиллагаагаа компанийн нэрийн өмнөөс явуулна.
- 2.6 Компанийн үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.
- 2.7 Компани нь төрийн болон бусад аж ахуйн нэгж байгууллага, түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад элсэн, ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлүүлэх, хамтран ажиллах зэргээр зохицуулалт хийнэ.
- 2.8 Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох мэдээлэл цуглуулах, мөн ийм мэдээллийг үйлчлүүлэгч, сонирхогчдод хүргэнэ.
- 2.9 Компани нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцална.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮНДСЭН ҮҮРЭГ

- 3.1 Компани нь энэхүү дүрмийн 1.7-д заасан үйл ажиллагааг Монгол улсын хуульд заасны дагуу эрхэлнэ.
- 3.2 Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.
- 3.3 Компани нь Монгол улсын татварын хуулиудын дагуу орлого, татвараа өөрөө тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.
- 3.4 Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.
- 3.5 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар өгөгдсөн эрх, үүргүүдийг биелүүлнэ.
- 3.6 Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивт шилжүүлнэ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА

- 4.1 Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хариуцлага хүлээнэ.
- 4.2 Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.



- 4.3Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.
- 4.4Компани нь Монгол улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

- 5.1Хувьцаа эзэмшигч нь Компанийн дүрэмд заасан журмын дагуу компанийн үйл ажиллагааг удирдахад оролцоно.
- 5.2Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5.3Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах эрхтэй. Ногдол ашгийг татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.
- 5.4Хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.
- 5.5Компани татан буугдах үед өр төлбөр барагдуулсны дараагаар компанийн үндсэн хөрөнгө худалдан борлуулсан орлогоос эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хувь хүртэх эрхтэй.
- 5.6Компанийн үйл ажиллагааны байдал, санхүүгийн байдал, бусад бичиг баримт мэдээ тайлантай танилцах эрхтэй.
- 5.7Компанийн эрх барих болон захиргааны байгууллагад санал оруулах, түүнийгээ хэлэлцүүлэх эрхтэй.
- 5.8Компанийн болон түүний шууд харьяа үйлдвэрийн бүтээгдэхүүн, гадаад дотоод зах зээлээс худалдан авч байгаа зүйлс, үзүүлж буй үйлчилгээг тэргүүн ээлжид авах эрхтэй.
- 5.9Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3, 89.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Компанийн тухай 12 дугаар бүлэгт заасан Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам нь Компанид хамраахгүй болно.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 6.1Хувьцаа эзэмшигч нь компанийн дүрэм, гэрээний заалтыг чанд сахиж компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлнэ.
- 6.2Компанийн хувьцааг давуу эрхээр худалдан авах тухай саналаа хувьцааг худалдах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлнэ.
- 6.3Компанийн нууцыг чандлан хадгална.
- 6.4Хувьцаа эзэмшигчид хоорондын харилцаанд чин шударгаар хандана.
- 6.5Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээгээр биелүүлнэ.
- 6.6Өөрийн буруутай үйлдлийн улмаас компанид учруулсан хохирлыг бүрэн хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.
- 6.7Хувьцаа эзэмшигч нь төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр түүний ногдох хувь буюу тухайн жилд олгогдвол зохих ногдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасаж болно. Ийм боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.
- 6.8Хувьцаа эзэмшигч нь энгийн хувьцаа, ногдол хувь эзэмших эрхээ бүгдийг буюу хэсэгчлэн гуравдагч этгээдэд худалдах буюу шилжүүлэх саналтай бол энэ тухайгаа компанид мэдэгдэх бөгөөд энэ тухай компани нь бусад хувьцаа эзэмшигч нарт бичгээр мэдэгдэнэ. Бусад хувьцаа эзэмшигчид хувьцааг давуу эрхийн дагуу тэргүүн ээлжид худалдан авах эсэхээ 30 хоногийн дотор мэдэгдэнэ. Энэ хугацаанд хариу мэдэгдээгүй бол мэдэгдэлд дурдсан хугацаанд шилжүүлэх, худалдахыг зөвшөөрсөн гэж үзнэ.



- 6.9Хувьцаа эзэмшигч нь компанийн гишүүнээс гарах тухай өргөдлөө хувь эзэмшигчдийн хуралд 1 сараас доошгүй хугацааны өмнө гаргана. Хувьцаа эзэмшигчийг компаниас гаргах тухай шийдвэр, дүрэмд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хувьцаа эзэмшигчийг компаниас гарсанд тооцно.
- 6.10Хувьцаа эзэмшигч компаниас гарсан тохиолдолд дор дурдсан хөрөнгө олгоно.
- 6.11Хувь нийлүүлсэн хөрөнгийнх нь үнэ /өртөг/
- 6.12Хувьцаа эзэмшигчид хуримтлагдсан ашгаас.
- 6.13Хувьцаа эзэмшигчид дараах зүйлийг хориглоно.
- 6.14Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолдоо ашиглахыг хориглоно.
- 6.15Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөд гэм хор учруулж болзошгүй аливаа үйлдэл хийхийг хориглоно.

ДОЛОО. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 7.1Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.
- 7.2Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 780, 112, 500 (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун) төгрөг байна. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 780, 112, 500 (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.
- 7.2.1Компанийн хувь нийлүүлэгчид дараах байдлаар гаргасан хувьцааг эзэмшинэ. Үүнд:

	Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр	Гаргасан хувьцаа 2025 он		Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		
			Нэг бүрийн	Бүгд	
1	“Таван Богд Холдингс” ХХК		1		
2	Олон нийт		1		
3	Нийт	780, 112, 500	1	780, 112, 500	100

- 7.3Хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, алдагдал хариуцах үүргийн хэмжээ болон компанийг татан булгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг эрхийг гэрчилнэ.
- 7.4Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.
- 7.5Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно.
- 7.6Шаардлагатай тохиолдолд хувь эзэмшигчдийн санаачилга, хамтын шийдвэрээр хувь нийлүүлсэн хөрөнгөд шинээр хөрөнгө оруулна.
- 7.7Компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгийн бүртгэл жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна. Энэхүү хөрөнгийг, тухайлбал үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгөд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний тайланг хавсаргаж баталгаажуулна.
- 7.8Компанийн хувьцаа, Компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.



НАЙМ. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 8.1
- Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 8.2
- Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 8.3
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.
- 8.4
- Компанийн гүйцэтгэх удирдлагыг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ. Компанийн гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- 9.1
- Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэг болон энэхүү дүрмийн 8.1-д заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх) байна.
- 9.2
- ХЭХ нь ээлжит болон ээлжит бус байна.
- 9.3
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор Төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулна.
- 9.4
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах шаардлагатай бол ажлын 3 хоногоос доошгүй 45 хоногоос хэтрэхгүй хугацаанд зарлан хуралдуулж болно.
- 9.5
- ХЭХ нь Компанийн тухай хуулийн 62.1 дэх заалтад заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.
- 9.6
- ХЭХ-аар хэлэлцэх асуудлыг шийдвэрлэхэд нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.
- 9.7
- ХЭХ-ын шийдвэр хүчин төгөлдөр болох, ХЭХ-д оролцох эрх, ХЭХ-ын зарыг хүргэх, ХЭХ-ын хэлэлцэх асуудалд санал оруулах, ХЭХ-ын тооллогын комисс, ХЭХ-д оролцох журам, ХЭХ-ын ирц, ХЭХ хүчин төгөлдөр болох, ХЭХ, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах, саналын хуудас, саналын хуудсыг хүчинтэйд тооцох, эчнээ санал хураалтаар компанийн хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргах, ХЭХ-ын тэмдэглэлтэй холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 63-74 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

АРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 10.1
- Компанийн тухай хуулийн 75.1 дэх хэсэг болон энэхүү дүрмийн 8.3-т заасны дагуу ХЭХ-ийн чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) байна.
- 10.2
- ТУЗ нь 5 ба түүнээс дээш гишүүнтэй байна. Бүтцийн хувьд ердийн гишүүд 3, хараат бус гишүүн 2 гишүүнээс бүрдэнэ.
- 10.3
- ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна.
- 10.4
- ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76.1-д заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.
- 10.5
- ТУЗ-ийн ээлжит хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурлыг хэдийд ч хийж болно.
- 10.6
- ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд түүнд хуралд оролцсон бүх гишүүд өөрийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсгээ зурна.
- 10.7
- ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцна. Мөн хурлын тухай зар, материалыг хурал хуралдахаас өмнө ТУЗ-ийн ажиллах журамд заасны дагуу гишүүдэд хүргэнэ.
- 10.8
- ТУЗ-ийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 10.9
- Энэ бүлэгт заагаагүй ТУЗ-тэй холбоотой бусад асуудлыг Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.



АРВАН НЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 11.1
- Компанийн Гүйцэтгэх удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 11.2
- Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрэм, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Ингэхдээ хэлцэл хийх, гэрээ байгуулах, тушаал шийдвэр гаргах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
- 11.3
- Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байх, өөр компани, аж ахуй нэгжийн гүйцэтгэх удирдлагад ажиллаж болно. Харин ТУЗ-ийн дарга байж болохгүй.
- 11.4
- Гүйцэтгэх захирал нь компанийн нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх болон бусад байдлаар компанийг төлөөлөхдөө тусгайлсан итгэмжлэл авахгүй бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 11.4.1
- Компанийн хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал боловсруулах, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулах хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 11.4.2
- Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрын захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулах, тэдэнтэй компанийг төлөөлөн контракт гэрээ байгуулах;
- 11.4.3
- Компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээнийн хүрээнд захиран зарцуулах;
- 11.4.4
- Компанийн дотоод журам, үйл ажиллагааны дүрэм, журам, зааврыг баталж, мөрдүүлэх;
- 11.4.5
- Өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах;
- 11.4.6
- ТУЗ-өөс олгосон эрх мэдлийн хүрээнд компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй шууд харилцаж, тэдэнтэй гэрээ, хэлэлцээр байгуулах;
- 11.4.7
- Компанийг төлөөлөх итгэмжлэл олгох;
- 11.4.8
- Компанийн бүтээгдэхүүний дотоод болон гадаад орнуудад мөрдөх үнэ, тарифыг батлан мөрдүүлэх;
- 11.4.9
- Монгол Улсын хууль тогтоомж, шийдвэр болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна. ТУЗ-өөс баталсан төсвийн хүрээнд компанийн бүтэц, орон тоог бие даан баталж мөрдүүлэх;
- 11.4.10
- Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцах;
- 11.4.11
- Хувьцаа эзэмшигчдийг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангах;
- 11.4.12
- ТУЗ-ийн хуралд компанийн хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны талаар тайлагнах.
- 11.5
- Гүйцэтгэх захирал нь ажлаа ТУЗ-д тайлагнах ба ТУЗ нь гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг хэдийд ч гаргах эрхтэй.
- 11.6
- Гүйцэтгэх захиралтай холбоотой бусад асуудлыг Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

АРВАН ХОЁР. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ХАРИУЦЛАГА

- 12.1
- ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал болон бусад захирал нэршилтэй албан тушаалтнуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 12.2
- Эрх бүхий албан тушаалтантай холбоотой бусад асуудлыг Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН

- 13.1
- Компани нь холбогдох хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.



- 13.2 Компанийн санхүүгийн жилийн эхлэх хугацаа жил бүрийн 1-р сарын 1, дуусах хугацаа 12-р сарын 31 байна.
- 13.3 Компани нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг Санхүү бүртгэлийн асуудал хариуцаж буй захирал нь Гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.
- 13.4 Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайлан гаргаж нийтлүүлнэ.
- 13.5 Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:
- 13.5.1 Баланс;
- 13.5.2 Орлого үр дүнгийн тайлан;
- 13.5.3 Мөнгөн гүйлгээний тайлан;
- 13.5.4 Хуримтлагдсан ашгийн тайлан;
- 13.5.5 Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн;
- 13.5.6 Удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал.
- 13.6 Санхүүгийн тайлан гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан санхүүгийн хөрөнгө оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.
- 13.7 Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу Сангийн сайдын баталсан санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй үзүүлэлтүүд, маягт, аргачлалыг мөрдөнө.

АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ. ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ

- 14.1 Компанийг ХЭХ-ийн шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.
- 14.2 Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-23 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.
- 14.3 Компанийн ХЭХ-ийн болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад хуульд заасан үндэслэл, журмаар татан буулгана.
- 14.4 Монгол Улсын шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана.Үүнд:
- 14.4.1 Дампуурсан;
- 14.4.2Нэг ч хувьцаа эзэмшигч үлдээгүй;
- 14.4.3Хуульд заасан бусад үндэслэл.
- 14.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгах комиссыг томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
- 14.6 Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.
- 14.7 Татан буулгах комисс нь “Компанийн тухай” хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно.
- 14.8 Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн



- компанид ямар нэг хохирол учруулсан бол уул хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.
- 14.9 Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

АРВАН ТАВ. АХМАДЫН САНГИЙН ТУХАЙ

- 15.1 Компани нь ажиллаж байсан ахмад настанд Ахмад настны тухай хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмадын сан” байгуулан ажиллуулна.
- 15.2 Ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээг гүйцэтгэх захирал нь 2 жилд нэг удаа Үйлдвэрчний эвлэл болон түүний дэргэдэх Ахмадын зөвлөлтэй хэлэлцэн тогтооно.

АРВАН ЗУРГАА. ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

- 16.1 Компанийн ТУЗ нь шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгыг хийх бол энэ талаар санал боловсруулан ХЭХ-д оруулж батлуулна.
- 16.2 Энэ дүрмийг Монгол хэлээр тус бүр 2 хувь үйлдэж, нэг хувийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.
- 16.3 Энэхүү дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Төгсөв.




ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Улаанбаатар хот

1. "Говь" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оруулсан компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл болон төслийг хэрэгжүүлэх журмыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчилснийг баталсугай.
3. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар Компанийн хэлбэр өөрчлөгдсөн ч Компанийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон ТУЗ-ийн бүрэн эрхийг Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны бүртгэлээс хасах тогтоол гаргах болон компанийн хэлбэр өөрчлөгдөж Улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэл хугацаанд үргэлжлүүлсүгэй.
4. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбоотойгоор хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулах, хувьцааны үнэлгээ хийлгэх, брокерын болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулах гэх мэт өөрчлөн зохион байгуулагдахад шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах, төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Хуулийн хэлтсийн дарга (Ц.Цасчихэр)-д олгосугай.
5. Компанийн хэлбэрээ өөрчилсөн "Говь" ХК-ийн эрх, үүрэг, хариуцлага нь шинээр бий болсон "Говь" ХХК-д шилжиж байгаа болон хуулийн этгээдийн оноосон нэр, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт ороогүй болохыг тус тус дурдсугай.
6. Компанийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч нь компанийн хэлбэрийг өөрчлөхөд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй бол өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй болохыг дурьдаж хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг ТУЗ-д даалгасугай.
7. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнийг тогтоон батлахыг ТУЗ-д даалгасугай.
8. Энэхүү шийдвэрийг толгой компани болон холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, бусад шаардлагатай ажиллагааг энэхүү шийдвэрийг үндэслэн итгэмжлэлгүйгээр хийж гүйцэтгэхийг Хуулийн хэлтсийн дарга (Ц.Цасчихэр)-д үүрэг болгосугай.

22



Улаанбаатар хот

1. “Говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар өөрчлөн байгуулахаар шийдвэрлэснийг дурдсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу “Говь” ХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох замаар өөрчлөн байгуулахтай холбогдуулан “Говь” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг Хавсралт 1-ээр шинэчлэн баталсугай.
3. Энэхүү шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх, гэрчилгээ хүлээн авах ажиллагааг хийж гүйцэтгэхийг Хуулийн хэлтсийн дарга (Ц.Цасчихэр)-д үүрэг болгосугай.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 07-р сарын 29-ний өдрийн хурлын
33-р тогтоолын 6-р хавсралт

“ГОВЬ” ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ТТН2998.ж.2076357

ГОВЬ ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга:

Ахлах аудитор

Т.Мөнхзул

Комиссын гишүүд:

Аудитын менежер

Д.Сарангуа

Нягтлан бодогч

Б.Ууганзаяа

Нягтлан бодогч

Б.Урангоо



САНАЛ АВАХ ХУУДАСНЫ ЗАГВАР

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 07-р сарын 29-ний өдрийн хурлын
33-р тогтоолын 2-р хавсралт

“ГОВЬ” ХК-ийн
ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ТТН2998.ж.2076357

ГОВЬ ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС

Хурлын өдөр: 2025 оны 9-р сарын 8-ны өдөр
Эхлэх цаг: 14:00 цаг
Байршил: ГОВЬ ХК-ийн өөрийн байр
(Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК-ийн өөрийн
байр, 1-р давхар, Сургалтын танхим)

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр:	
Иргэний бүртгэлийн дугаар: /Хуулийн этгээдийн хувьд регистрийн дугаар/	
Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо:	
Утасны дугаар:	
И-мэйл хаяг:	

САНАЛ ХУРААХ АРГА: ЭНГИЙН АРГА

№	Шийдвэр гаргаж, батлах асуудал	Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн хэлбэрийг өөрчлөх	Компанийн хэлбэрийг өөрчлөх тухай	☐	☐	☐	
2	Компанийн дүрмийг шинээр батлах	Компанийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай	☐	☐	☐	

Огноо: 2025 оны ... -р сарын ... -ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Санал өгөх заавар:

Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож (✓эсвэл +) тэмдэг тавина.
Жишээ нь: зөвшөөрсөн бол "Зөвшөөрсөн" гэсэн нүдэнд (✓ эсвэл +), татгалзсан бол "Татгалзсан" гэсэн нүдэнд (✓эсвэл +), түдгэлзсэн бол "Түдгэлзсэн" гэсэн нүдэнд (✓эсвэл +) тэмдэг тавина.

Хэрэв татгалзсан бол "Таны өгөх санал" гэсэн нүдэнд уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх саналтай байгаагаа бичнэ.

Хүчингүй саналын хуудас: Засварласан, балласан, (✓ эсвэл +)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн, нэгээс олон санал бөглөсөн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.



Санамж:

- **Урьдчилан санал өгөх:** Саналын хуудсыг бөглөж дараах арга хэлбэрээр **2025** оны **9-р** сарын **4-ний** өдрийн дотор иргэний үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ)-ний хуулбарын хамт ирүүлнэ үү:
 - Өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан өгөх;
 - Говь ХК дээр биечлэн ирж өгөх;
 - Шуудангаар илгээх: Монгол Улс, УБ-17062, Шуудангийн хайрцаг-36/434, "Говь" ХК);
 - И-мэйлээр ирүүлэх: boardoffice@gobicashmere.com

Жич: Та урьдчилан санал өгсөн тохиолдолд дахин санал өгөх эрхгүй болно.

- **Төлөөлүүлэн санал өгөх:** Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөн, **нотариатаар баталгаажуулсан байх** шаардлагатай.

Тооллогын комисс бөглөх хэсэг:

Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар	Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх	Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан
	☐ Тийм ☐ Үгүй	



"ГОВЬ" ХК,
ҮЙЛДВЭРИЙН ГУДАМЖ, 3-Р ХОРОО, ХАН-УУЛ ДҮҮРЭГ,
УЛААНБААТАР-17062, МОНГОЛ УЛС, Ш/Х 36/434

УТАС: +976 7013-9977, ФАКС: +976 7014-3081
И-МЭЙЛ: INFO@GOBI.MN